



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/564

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 78 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн 78 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 4 нэр төрлийн нийт 565,900.00 (таван зуун жаран таван мянга есөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 78 дугаар цэцэрлэг (Л.Гантуяа)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 3 нэр төрлийн 165,900.00 (нэг зуун жаран таван мянга есөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгах, татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 1 нэр төрлийн 400,000.00 (дөрвөн зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Сонгинохайрхан дүүргийн 78 дугаар цэцэрлэг (Л.Гантуяа)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150501675

Нийслэлийн Өмчийн хар
дартын 2024 оны 11 с. дүгээ
өдрийн А/54 дугаар туш

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 78 дугаар цэцэрлэг

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын санал	Мэргэжлийн санал	УХХХК-ын шийдвэр
1. Тоног төхөөрөмж													
1	Хөргөгч	2	ш	1	400,000.00	400,000.00	400,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	татах	
Тоног төхөөрөмжийн нийт үнэ													
400,000.00													
2. Тавилга эд хогшил													
1	Нуруулдагч	2	ш	1	40,000.00	40,000.00	98,700.00		эвдэрсэн	актлах		устгах	
2	Тавиур	2	ш	7	3,700.00	25,900.00	93,500.00		эвдэрсэн	актлах	1,000	устгах	
3	Багшийн ширээ	2	ш	2	50,000.00	100,000.00	89,900.00		эвдэрсэн	актлах	2,000	устгах	
Тавилга эд хогшлын нийт үнэ													
165,900.00													
Нийт дүн													
565,900.00													
Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгө													
Татан төвлөрүүлэх													
Устгах хөрөнгө													
400,000.00													
165,900.00													
Худалдсанаас олох орлого													
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/													